# “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН
# ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР САНХҮҮЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТИЙН УДИРДАМЖ

## Нэг. Оршил

2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Хамтын ажиллагааны гэрээг “Оюу Толгой” ХХК, Өмнөговь аймаг, Өмнөговь аймгийн Ханбогд болон бусад Түншлэгч сумдын хооронд байгуулсан. 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Хамтын ажиллагааны гэрээний дагуу бие даасан хуулийн этгээд болох “Говийн Оюу Хөгжлийг дэмжих сан” (“Говийн Оюу ХДС” буюу “ХДС”)-г байгуулж, Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн бөгөөд энэхүү сан нь “Говийн Оюу ХДС”-гийн Дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

“Говийн Оюу ХДС” нь Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдад хэрэгжих нийгмийн дэд бүтэц болон өргөн хүрээний эдийн засгийн оролцоог хангахад чиглэсэн Төсөл, Хөтөлбөрүүдийг дэмжиж, Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдын сайн сайхан байдал болон чадавхыг дээшлүүлэхийг эрмэлзэнэ.

## Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

Дор дурдсанаас бусад тохиолдолд энэхүү Санхүүжилтийн удирдамж (“Удирдамж”) дахь үг, хэллэгүүд нь Хамтын ажиллагааны гэрээнд тодорхойлсонтой адил утгатай байна.

**ХДС** гэж Хамтын ажиллагааны гэрээний 8 дугаар зүйлийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд болох “Говийн Оюу Хөгжлийг дэмжих сан”-г хэлнэ.

**ХДС-гийн Удирдах зөвлөл** гэж Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 3-ын 2 дахь хэсэгт заасны дагуу бүрдсэн удирдах зөвлөлийг хэлнэ.

**ХДС-д ирүүлсэн санал** гэж ХДС-д ирүүлсэн Төсөл эсхүл Хөтөлбөрийн саналыг ойлгоно.

**Санхүүгийн дэмжлэг** гэснийг Хамтын ажиллагааны гэрээний 8.3 дахь хэсэгт заасан утгаар ойлгоно.

**Итгэмжлэгдсэн зөвлөх** гэж Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 3-ын 3.4-т заасны дагуу томилогдсон этгээдийг ойлгоно.

**Гүйцэтгэх захирал** гэж тухай бүр “Говийн Оюу ХДС”-гийн гүйцэтгэх захирлаар томилогдсон этгээдийг хэлнэ.

**Харилцааны хороо** гэж Хамтын ажиллагааны гэрээний 4 дүгээр зүйлийн дагуу үүсгэн байгуулагдсан хороо бөгөөд “Оюу Толгой” ХХК-ийн төлөөлөгчид, Өмнөговь аймаг болон Ханбогд сумын төлөөлөгчдөөс (Орон нутгийн төлөөлөгчид) бүрдэнэ. Хороо нь Хамтын

ажиллагааны гэрээний Хавсралт 2-т заасан зарчим болон тухай бүр Төлөөлөгчдөөс баталсан бодлого, удирдамжийн дагуу дагуу үйл ажиллагаагаа явуулна.

**Харилцааны хорооны нарийн бичгийн дарга** гэж Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 2-ын 6 дахь хэсэгт заасны дагуу томилогдсон этгээдийг хэлнэ.

**Түншлэгч сумд** гэж Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай болон Даланзадгад сумдыг ойлгоно.

**Зорилтот сумд** гэж Өмнөговь аймгийн Цогтцэций, Баяндалай, Булган, Номгон, Сэврэй, Цогт-Овоо, Мандал-Овоо, Хүрмэн, Ноён, Ханхонгор, Гурвантэс сумдыг ойлгоно.

**Төсөл** гэж тухай бүр ХДС-гийн Удирдах зөвлөлөөс баталсан бодлого, журамд заасны дагуу ХДС-аас санхүүжүүлэхийг дэмжиж баталсан Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдад үр өгөөж бий болгох буюу тэдгээрийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор баригдсан аливаа биет зүйл, барилга, байгууламжийг ойлгоно.

**Хөтөлбөр** гэж тухай бүр ХДС-гийн Удирдах зөвлөлөөс баталсан бодлого, журамд заасны дагуу ХДС-аас санхүүжүүлэхээр баталсан Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдыг хөгжүүлэх буюу түүний нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааг ойлгоно.

**Сэдэвчилсэн хавсралт** гэснийг Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 4-10-г ойлгоно.

**Гурав. Санхүүжилтийн удирдамжийн зорилго**

Энэхүү Удирдамж нь санхүүжилтийн зарчим, тэргүүлэх чиглэлүүд, хуваарилалт, эрх бүхий өргөдөл гаргагч зэрэг санхүүжилтийн шалгуурт хэрэглэгдэх үндсэн зарчмуудыг тогтооно.

ХДС-гийн Удирдах Зөвлөл шаардлагатай эсвэл тохиромжтой гэж үзвэл эдгээр зарчмуудыг тухай бүр шинэчилж болно. Ийнхүү шинэчлэхдээ ХДС-гийн Удирдах зөвлөл нь энэхүү удирдамжид заасан зарчмуудын дэлгэрэнгүй тайлбарыг оруулах ба тэдгээр зарчмуудад нийцсэн, санхүүжилтийн дэмжлэг авах боломжтой төслийн төрөл, шинж чанаруудыг тодорхойлж болно. Тэдгээр дэлгэрэнгүй тайлбаруудыг Удирдамжид Хавсралтаар оруулж болно.

Санхүүжилтийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл, санхүүжилтээр хэрэгжиж буй Төсөл, Хөтөлбөрийн явц зэргийг мэдээлэл, бизнесийн үйл ажиллагааны нууцлал, Хамтын ажиллагааны гэрээний дагуу "Оюу Толгой" ХХК-аас хүлээж авсан санхүүжилтийн хэмжээ зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр "Говийн Оюу ХДС"-гийн Удирдах зөвлөлөөс зөвшөөрөгдсөн хэлбэрээр олон нийтэд ил болгоно.

"Говийн Оюу ХДС" нь үйл ажиллагааны зардлаа өөрөө хариуцах бөгөөд Хамтын ажиллагааны гэрээний дагуу "Оюу Толгой ХХК"-иас хүлээж авсан санхүүжилт эсвэл "Говийн Оюу ХДС"-гийн олсон бусад орлогоос төлнө.

**Дөрөв. Санхүүжилтийн тэргүүлэх чиглэлүүд ба хуваарилалтын зарчим**

**4.1. Тэргүүлэх чиглэлийн Төсөл, Хөтөлбөр болон Санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилах**

Хамтын ажиллагааны гэрээний Сэдэвчилсэн хавсралтын заалтуудтай уялдсан дараах Төсөл, хөтөлбөрүүдийг Санхүүжилтийн дэмжлэгээс санхүүжүүлнэ. Төсөл, Хөтөлбөрүүдийн гол салбаруудыг дор тодорхойлов. ХДС-гийн Удирдах Зөвлөл болон Харилцааны хороо нь ХДС-д ирүүлсэн саналыг хянаж, холбогдох шийдвэрийг гаргахдаа дараах хуваарилалтын зарчмыг баримтална.

a. Нийгмийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрууд – 48 хүртэл хувь

b. Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрууд – 40 хүртэл хувь

c. “Хойч үеийн төлөө сан”– 6 хувь

- Бичил зээлийн хөтөлбөр
- Оюутны тэтгэлэг/дэмжлэг
- Хадгаламж

d. Өмнөговь аймагт үзүүлэх хандив, тусламж – 1 хувь

e. ”Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн үйл ажиллагааны зардал - жилийн төсөв нь тухайн жилийн нийт санхүүжилтийн дэмжлэгийн 5% (таван хувь) хүртэл байна. Удирдах зөвлөл нь үйл ажиллагааны зардал - жилийн төсвийг ХДС-гийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тухайн жилд гүйцэтгэх ажлын цар хүрээтэй уялдуулан баталж, удирдлагаар хангана.

Дээрх хуваарилалт нь зөвхөн чиглэл өгөх зарчмууд юм. ХДС-гийн Удирдах зөвлөл нь Хамтын ажиллагааны гэрээ болон Сэдэвчилсэн хавсралтуудын (тухай бүр өөрчлөгдөж болох) зарчмууд, ХДС-гийн зорилгод үндэслэн эрэмбэлэгдсэн Төсөл, Хөтөлбөрүүд болон тэдгээрийн санхүүжилтийн хуваарилалтын зарчимд тухай бүр нэмэлт, өөрчлөлтийг оруулж болно.

**4.2. Тэргүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн тодорхойлолт**

**1. Нийгмийн дэд бүтцийн төслүүд**

Эдгээр төслүүд нь Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдын амьдралын түвшин, сайн сайхан байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах нийтийн ашиглалтын дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг барьж байгуулах, суурилуулах биет төслүүд болно. Сайн засаглалын эерэг үзүүлэлттэй, нийгмийн дэд бүтцийн олон төрлийн төслүүдийг хэрэгжүүлж байсан туршлагатай, зардлын үр ашигтай удирдлага бүхий байгууллага, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас гаргах төслийн саналд тэргүүлэх ач холбогдол өгнө. Энэхүү удирдамжийн Хавсралт 3-т онцгойлон авч үзэх нийгмийн дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийн жишээ, тайлбарыг дэлгэрэнгүй оруулна (Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралтын дагуу ангилсан бусад онцгойлон авч үзэх төсөл хөтөлбөрүүдийн хамт).

**2. Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүд**

Тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүд нь иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн бүлгүүд болон төрийн байгууллагуудаас санаачилж, боловсруулж, удирдан хэрэгжүүлэх биет бус хөтөлбөрүүд юм. Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг нэг удаа эсхүл үргэлжилсэн байдлаар хэд хэдэн удаа олгож болно.

Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд олгох жилийн нийт санхүүжилтийн тодорхой хэсгийг Түншлэгч болон Зорилтот сумдад квот тогтоон хуваарилах замаар сумдын удирдлага, иргэдийн оролцоонд тулгуурлан тэдгээр сумдын болон Өмнөговь аймгийн нийгмийн эмзэг бүлэг болон гишүүдийг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнууд, тусгай дэмжлэг шаардлагатай хүмүүсийн амьдрал ахуй, биеийн эрүүл мэнд болон эдийн засгийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах, хуваарилахыг эрмэлзэнэ.

Тухайн жилд Түншлэгч болон Зорилтот сумдад дээрх зорилгоор хуваарилах хуанлийн 1 жилийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тогтооно:

- Ханбогд суманд 85000 ам.доллартой тэнцэх төгрөг
- Манлай, Баян-овоо, Даланзадгад сумдад тус бүрд 65000 ам.доллартой тэнцэх төгрөг
- Цогтцэций, Баяндалай, Булган, Номгон, Сэврэй, Цогт-Овоо, Мандал-Овоо, Хүрмэн, Ноён, Ханхонгор, Гурвантэс сумдад тус бүрд 45000 ам.доллартой тэнцэх төгрөг

### 3. “Хойч үеийн төлөө сан”

“Говийн Оюу ХДС” нь жилийн нийт Санхүүжилтийн 6 хувийг хойч үедээ зориулан хуваарилна (“Хойч үеийн төлөө сан”). Энэхүү сан нь “эргэлтийн сан”-гийн хэлбэртэй байх бөгөөд энэ сангаас жижиг, дунд үйлдвэрүүд бизнесийн гараагаа эхлүүлэх болон бизнесээ өргөжүүлэхэд хөрөнгө оруулах зорилгоор зээл авч болно. Түүнчлэн тус сангаас Өмнөговь аймгийн оюутнуудад тэтгэлэг олгоно.

Хойч үеийн төлөө санг банк гэх мэт санхүүгийн байгууллага удирдаж, Өмнөговь аймгийн иргэдэд зориулсан бичил санхүүгийн хөтөлбөрүүдийг дэмжинэ. Хойч үеийн төлөө санг бий болгож, удирдах банкны байгууллага нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй бизнесийн байгууллага байх бөгөөд “Говийн Оюу ХДС” болон Монгол Банкнаас тавьсан шалгуурыг хангасан байх шаардлагатай. “Говийн Оюу ХДС” нь тухайн банк, банк санхүүгийн байгууллагыг санхүүжилт авах эрх бүхий өргөдөл гаргагч, олгох мөнгөний хэмжээ болон “Хойч үеийн төлөө сан”-гийн зорилт, зориулалт болон үйл ажиллагааны нөхцөлийн талаарх удирдамж, журмаар (тухай бүр нэмэлт өөрчлөлт орж, өөрчлөгдөж болох) хангана.

Түүнчлэн тухайн банкны байгууллага нь “Хойч үеийн төлөө сан”-гийн нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, тогтвортой үйл ажиллагаа, зардлын үр ашигтай байдлыг бэхжүүлэх нэмэлт болон өрсөлдөхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох, “Хойч үеийн төлөө сан”-гийн удирдлага, тус сангаас дор хаяж 10 жилийн хугацаатайгаар зээл авах, зээл олгохтой холбоотой эрсдэлийг удирдах болон бууруулахад чиглэсэн хүчин төгөлдөр, заавал хэрэгжих боломжтой баталгаа гаргах болон/эсхүл эрсдэлийн сан байгуулах (эсхүл адилтгах арга хэмжээ авах) чадвартай

байна. “Говийн Оюу ХДС” нь “Хойч үеийн төлөө сан”-гийн талаар банк, санхүүгийн байгууллагатай шаардлагатай гэрээ хэлцлийг байгуулна.

**4. Өмнөговь аймагт үзүүлэх хандив, тусламж**

Хандив болон тусламжийг зорилтот хүлээн авагч нарт үзүүлж болох бөгөөд үүнд спорт, соёлын үйл ажиллагаа, хурал болон тэмцээн уралдааныг дэмжих санхүүжилт орж болно.

**5. Жилийн үйл ажиллагааны зардал**

Жилийн үйл ажиллагааны зардалд “Говийн Оюу ХДС"-гийн үйл ажиллагаатай холбоотой Хамтын ажиллагааны гэрээг зөв зохистой ил тод хэрэгжүүлэхэд шаардагдах удирдлага, зохион байгуулалт, ажилтантай холбоотой зардлууд багтана.

**6. Санхүүжилтийн бусад эх үүсвэр**

ХДС-гийн Удирдах Зөвлөлөөс баталсан Санхүүжилтийн эх үүсвэрээс гадна бусад ивээн тэтгэгч, хөрөнгө оруулагч нараас олгосон санхүүгийн дэмжлэг эсхүл хувь тэнцүүлэн олгосон санхүүжилт, мөнгөн бус хандивыг Төсөл, Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглаж болно. Нийгэмд үзүүлэх эерэг нөлөөг ихэсгэх, зардлаа хуваах зорилгоор “Говийн Оюу ХДС” нь орон нутгийн удирдлага гэх мэт талуудтай ажиллан, тэдгээр талууд хувь тэнцүүлэн, эсхүл их хэмжээний дэмжлэг үзүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж, онцгойлон авч үзнэ. ХДС-гийн Удирдах зөвлөл нь төсөл, хөтөлбөр хамтран санхүүжүүлэх талыг сонгохдоо энэхүү удирдамжид заасан бусад холбогдолтой заалт болон хамтран санхүүжүүлэгчийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх чадвар, сонирхлыг харгалзан үзэж сонгоно.

**7. Ханбогд сумыг тусгайлан дэмжих**

Ханбогд сум нь Оюу толгой төсөл болон түүний нөлөөлөлд (бодит болон болзошгүй) хамгийн ойр орших орон нутаг бөгөөд ХДС-д ирүүлсэн саналыг шалгаруулах, санал болгох, шийдвэрлэхдээ энэхүү Удирдамжид заасан бусад шалгуураас гадна Ханбогд сум болон түүний хүн амын нийгмийн дэд бүтэц, амьжиргаа, сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн Төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид тавина. Иймд “Говийн Оюу ХДС” жил тутам Ханбогд суманд үр өгөөжөө шууд өгөх, Ханбогд суманд хэрэгжих дор хаяж нэг дэд бүтцийн Төсөлд санхүүжилт олгохыг зорино.

**Тав. Зорилтот бүлэг болон хүлээн авагч**

Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдад бүртгэлтэй бөгөөд оршин сууж буй аливаа хувь хүн нь “Говийн Оюу ХДС”-аас дэмжих Төсөл, хөтөлбөрүүдийн зорилтот хүлээн авагч болно. Үүнд ялангуяа:

- Хүүхэд, залуучууд
- Малчид
- Эмзэг бүлгийн хүн ам
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

- Эмэгтэйчүүдийг нэн тэргүүнд харгалзан үзэх хүлээн авагчид гэж үзнэ.

**Зургаа. Санхүүжилт олгох шалгуур**

“Говийн Оюу ХДС”-гийн санхүүжилтээр хэрэгжих Төсөл, Хөтөлбөр нь Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдын нийгмийн сайн сайхан байдал болон өргөн хүрээний нийгэм, эдийн засгийн оролцоонд үр өгөөжөө өгөхөд чиглэсэн Төсөл, хөтөлбөрүүдээр дамжуулан Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдад тогтвортой чадавх бий болгох “Говийн Оюу ХДС”-гийн эрхэм зорилт, стратегийг хөхиүлэн дэмжихэд нөлөө үзүүлэх ёстой. Иймд Төсөл, Хөтөлбөрийг сонгоход дараах шалгууруудыг харгалзан үзнэ. Үүнд:

- Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдад хэрэгжүүлэх
- Тэргүүлэх төсөл, хөтөлбөрийн чиглэлүүдтэй уялдсан байх
- Орон нутгийн иргэдийн амьжиргаанд шууд эерэг нөлөөлөл үзүүлж, тогтвортой үр өгөөж авчрах
- Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдээр хэмжиж, аудит хийж болохуйц тодорхой үр дүн гаргах
- Санал болгож буй төслийг хэрэгжүүлэх тодорхой хуваарьтай (гүйцэтгэлийн хүрэх түвшин болон цаг хугацааны хуваарийг тодорхойлсон) байх
- Зорилтот бүлэг эсвэл орон нутгийн иргэд, гишүүдийг оролцуулж, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байх
- Тодорхой, ил тод худалдан авалтын бодлого, журмуудтай байх
- Нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх төслүүд дээр эрсдэлийн үнэлгээ хийх ба эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, нийгэмд учирч болох эрсдэлүүдийг багасгах үнэлэлт хийх, авах арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байх. Уг арга хэмжээ нь Монгол Улсын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчинтой холбоотой хууль тогтоомж болон “Оюу Толгой” ХХК-ийн хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байх
- Эрх бүхий өргөдөл гаргагч болон Төсөл, Хөтөлбөрийн гэрээт гүйцэтгэгчид нь бизнесийн үйл ажиллагаагаа шударгаар, аливаа авлига, хээл хахууль (бодит болон боломжит)-аас ангид, аливаа улс төрийн бүлэг эсвэл байгууллагын ашиг сонирхол, хөтөлбөрийг дэмжиж, туслахгүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг нэр хүндтэй гэдгээ харуулсан байх
- Эрх бүхий өргөдөл гаргагч нь төсөл, хөтөлбөрийн тогтвортой байдал болон үр ашигтай байдлыг (төсөв, зардал, харилцагчид, ажиллах хүч болон үйл ажиллагаагаа тогтвортой явуулах бусад эх үүсвэр, төсөл, хөтөлбөрийн үр ашгийг амжилттай хүртэх болон ялангуяа дэд бүтцийн төслүүдтэй холбоотойгоор хууль тогтоомжийн шаардлагыг хангах үүднээс байнгын хяналт тавих) харуулсан байх
- Төсөл, хөтөлбөрийг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, хүлээлгэж өгөхөд саад болох аливаа өр, санхүүгийн зөрчил, нэхэмжлэл эсвэл алдагдалгүй (бодит болон болзошгүй) байх. “Говийн Оюу ХДС” нь итгэмжлэгдсэн аудитын байгууллагаар аудит хийлгэсэн Эрх бүхий өргөдөл гаргагч болон Төсөл, Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч гэрээт гүйцэтгэгчээс санхүүгийн тайлан болон ХДС-гийн санхүүжилтийг зөвхөн батлагдсан төсөл,

хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглах, өөр зорилгод ашиглахаас хамгаалах арга хэмжээ авахыг шаардах эрхтэй.

Дээр дурдсан болон бусад шалгууруудад нийцсэн эсэх ба ХДС-гийн саналын тогтвортой байдлыг үнэлэх зорилгоор "Говийн Оюу ХДС" (Гүйцэтгэх захирал эсвэл Удирдах зөвлөл) нь төслийн санал батлагдах түвшинд хүрэхээс өмнө инженер, санхүү, хуулийн болон бусад хяналт хийлгэх болно.

**Долоо. ХДС-гийн санхүүжилтийг түдгэлзүүлэх, зогсоох**

"Говийн Оюу ХДС" нь дараах тохиолдлуудад ХДС-гийн санхүүжилтийг түдгэлзүүлэх эсвэл зогсоох эрхтэй:

Төсөл, хөтөлбөрийн үйл явцад ахиц гараагүй, хэрэгжүүлэх хуваариас их хэмжээгээр зөрсөн, гүйцэтгэл, хэрэгжилтийн төлөвлөгөөг биелүүлээгүй, үйл ажиллагааны үр дүн нь аюултай, бүрэн бус, стандартад нийцээгүй үр дүнд хүрсэн ба эрх бүхий өргөдөл гаргагч болон төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгч нь аливаа авлигын үйл ажиллагаа, үйлдэлд ямар нэгэн байдлаар холбогдсон.

**Найм. "Говийн Оюу ХДС"-аас Хүлээн авахгүй өргөдөл**

"Говийн Оюу ХДС" нь дараах өргөдлийг хүлээн авч, судлан үзэхгүй:

- Шашны эсвэл улс төрийн байгууллагыг дэмжих зорилготой
- Өмнөговиос гадна хэрэгжих төсөл, хөтөлбөр
- Байгууллагын үйл ажиллагааны зардлыг хариуцах
- Хувь хүний аялал, эмчилгээний болон уралдаан тэмцээнд оролцох зардал
- Энэхүү санхүүжилт олгох журмаас ангид урьдчилан эхлүүлсэн төсөл
- Алдагдлаа нөхөх болон яаралтай санхүүжүүлэх төсөл
- Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагын санаачилсан төсөл, хөтөлбөр.

**Ес. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараалал**

ХДС-ийн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг дараах гурван үндсэн хэсэгт хуваарилна. Үүнд:

1. (Түншлэгч болон Зорилтот сумд)-д олгох санхүүжилтийн квот,
2. Нийгмийн дэд бүтцийн төсөл,
3. Нийгмийн тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөр.

## Нийгмийн дэд бүтцийн төслийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны дараалал:

| | Үе шат | Үйл ажиллагаа | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Хэрэгжүүлэх шаардлагатай | Аймгийн ЗДТГ нь ХДС-ийн хөгжлийн гурван жилийн үндсэн чиглэлийн дагуу жилд нэг удаа буюу 07 сарын 15- | Жил бүрийн 07 дугаар |

| | | | |
|---|---|---|---|
| | төслийн санал хүлээн авах | ны дотор дараа жил хэрэгжүүлэх шаардлагатай нийгмийн дэд бүтцийн төсөлтэй холбоотой саналуудыг дараах ангиллын дагуу ХДС-д ирүүлнэ. Үүнд:<br>1. Зураг төсөл боловсруулах шаардлагатай нийгмийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийн саналууд<br>2. Зураг төсөл нь батлагдсан нийгмийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийн саналууд<br>• Аймгийн ЗДТГ нь ХДС-аас санхүүжүүлэх нийгмийн дэд бүтцийн төслийн санал, хүсэлтийг заасан хугацааны дотор бичгээр ХДС-д ирүүлнэ.<br>• Аймгийн ЗДТГ-аас ирүүлж буй саналд менежмент, тоног төхөөрөмжийн зардал болон тогтвортой байдлын төлөвлөгөөг багтаасан байх шаардлагатай бөгөөд ХДС-ийн санал бүртгэх маягтын дагуу бөглөж ХДС-ийн ажлын албанд хүлээлгэн өгнө.<br>• Аймгийн ЗДТГ-аас ирүүлж буй энэ нийгмийн дэд бүтцийн төсөл нь орон нутгийн иргэд, ТББ, аж ахуй нэгж байгууллагуудын хэрэгцээ шаардлага, санал, хүсэлтэд тулгуурласан байх ба холбогдох баримт нотолгоо, үндэслэлийг ХДС-д ирүүлнэ. | сарын 15-ны дотор |
| 2 | Нөхцөл байдлын шинжилгээ хийх | Сангийн гурван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай нийгмийн дэд бүтцийн төсөл байгаа эсэхийг шалган тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэнэ.<br>• ХДС-д ирүүлсэн нийгмийн дэд бүтцийн төслийн саналууд нь орон нутгийн иргэд, ТББ, аж ахуй нэгж байгууллагуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн, санал, хүсэлтэд тулгуурласан байх ба холбогдох баримт нотолгоонд үндэслэсэн эсэхэд хяналт тавина.<br>• Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн нийгмийн дэд бүтцийн төслийн санал болон жагсаалтуудыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор ХДС-ийн дүрэм, санхүүжилтийн удирдамж зэрэг холбогдох баримт бичгүүдэд дурдсан шаардлагуудыг хангасан эсэх талаар ХДС нь нөхцөл байдлын шинжилгээ хийнэ.<br>• ХДС нь нөхцөл байдлын шинжилгээнд тулгуурлан ирүүлсэн санал тус бүрийг хэрэгжүүлэх боломжтой | 08 дугаар сарын 01-ны дотор |

| | | | |
|---|---|---|---|
| | | эсэхийг тодорхойлсон тайлбарын хамт Харилцааны хороонд хүргүүлнэ. | |
| 3 | Хүлээн авсан саналуудыг эрэмбэлэх | • Харилцааны хорооны хурлаар ХДС-д ирүүлсэн төслийн саналуудыг хэлэлцэж, дараах хоёр ангилал тус бүрээр эрэмбэлнэ.<br>1. Зураг төсөл боловсруулах шаардлагатай нийгмийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийн саналууд<br>2. Зураг төсөл нь батлагдсан нийгмийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийн саналууд | 08 дугаар сар |
| 4 | Санхүүжилт олгох шийдвэр гаргах | • Харилцааны хорооноос дэмжигдсэн саналуудыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн санхүүжилт олгох эсэх талаар шийдвэр гаргана.<br>• Удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүжилт олгохоос татгалзсан тохиолдолд ХДС нь энэ тухай Аймгийн ЗДТГ-т мэдэгдэнэ | 09 дүгээр сар |
| 5 | Шийдвэрийг мэдээлэх | • Удирдах зөвлөлөөс санхүүжүүлэх шийдвэр гаргасан, батлагдсан зураг төсөлтэй нийгмийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг тендер зарлах үе шат руу шилжүүлнэ. | 09 дүгээр сар |
| 6 | Үнэлгээний хороо байгуулах<br>(Зураг төсөл боловсруулах шаардлагатай төслүүдэд хамаарна) | • Аймгийн ЗДТГ нь тухайн нийгмийн дэд бүтцийн төслийн саналтай холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоо бүхий Үнэлгээний хороог байгуулна. Үнэлгээний хороо нь зураг төсөл боловсруулах шаардлагатай төслийн саналд анхан шатны техникийн тодорхойлолт болон төсвийн төсөөлөл боловсруулан ХДС-д ирүүлэх бөгөөд ХДС нь Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн гишүүдээс санал авч, санал, зөвлөмжийг нэгтгэн Үнэлгээний хороонд хүргүүлнэ. Талууд анхан шатны техникийн тодорхойлолтыг хянан үзэж, саналаа бичгээр, ажлын 14 хоногийн дотор ХДС-д хүргүүлнэ.<br>• Үнэлгээний хороо нь Оюу толгой ХХК-ийн холбогдох хэлтэс, Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн саналуудад үндэслэн техникийн тодорхойлолтыг эцэслэн боловсруулна. | 10 дугаар сар |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Тендер зарлах | • Аймгийн ЗДТГ, Удирдах зөвлөлөөс санхүүжүүлэхээр баталсан батлагдсан зураг төсөлтэй төслийн саналуудад болон Үнэлгээний хорооноос боловсруулсан техникийн тодорхойлолт, зураг төсөлтэй боловсруулах шаардлагатай төслийн саналуудад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сонгон шалгаруулалт\тендер зохион байгуулна.<br>• Сонгогдсон Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсны дараа тус гэрээний хуулбарыг албан тоотын хамт гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор ХДС-д хүргүүлнэ. | 10 дугаар сараас хойш |
| 8 | Санхүүжилтийн гэрээ байгуулах, санхүүжилт олгох | • Захиалагчаас албан тоотоор ирүүлсэн гэрээнд үндэслэн ХДС нь Захиалагч, Гүйцэтгэгчтэй санхүүжилтийн гэрээг байгуулна. Уг гэрээг байгуулахаас өмнө төслийн ажлыг эхлүүлэхгүй.<br>• Санхүүжилтийн гэрээг ажлын 14 хоногийн дотор байгуулна. Шаардлагатай тохиолдолд (нэмэлт материал бүрдүүлэх, холбогдох зөвшөөрөл авах г.м) энэ хугацааг сунгаж болно.<br>• Санхүүжилтийн гэрээ байгуулахдаа бүх төслүүдэд урьдчилгаа санхүүжилт олгохгүй, зөвхөн ажлын гүйцэтгэлээр олгох нөхцөлөөр хийнэ.<br>• Санхүүжилтийг гүйцэтгэлийн тайлан баталгаажуулсан захиалагчийн албан бичигт үндэслэн гүйцэтгэгчид шууд олгоно. | Тухай бүр |
| 9 | Төслийн хэрэгжилтэд, хяналт тавих | • ХДС-ийн Хяналт, шинжилгээ- үнэлгээний журмын дагуу Захиалагч, ХДС, тэдгээрийн төлөөлөгчид төслийн аль ч үе шатанд хяналт тавина.<br>• Төслийн хэрэгжилтэд хяналт тавих болон санхүүжилтийг дуусгавар болгох үйл ажиллагааг ХДС-ийн Хяналт, шинжилгээ- үнэлгээний журмын дагуу зохион байгуулна | Төслийн санхүүжилтийн үе шатуудад |
| 10 | Төслийн хэрэгжилтийн талаар мэдээлэл авах | • Төслийн саналд тусгасан төслийн тогтвортой байдлын төлөвлөгөөний дагуу Захиалагч, ашиглагч байгууллагууд нь тогтвортой байдлыг хангаж ажиллана. | Төслийн санхүүжилтийг бүрэн олгож дууссанаас хойш |

## Нийгмийн тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дараалал

| | Үе шат | Үйл ажиллагаа | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт бүрээр ХДС-ийн баримтлах гурван жилийн үндсэн чиглэлийг тодорхойлох | • ХДС-ийн Удирдах зөвлөлөөс ХДС-ийн  баримтлах гурван жилийн үндсэн чиглэлийг тодорхойлно. (2017-2019 оны хооронд баримтлах үндсэн чиглэлийг 2017 оны 07 сарын 05-ны өдөр 14 дугаартай тогтоолоор баталсан)<br>• Цаашид ийнхүү тодорхойлохдоо аймгийн удирдлага, иргэд, төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулна.<br>• Гурван жилийн үндсэн чиглэл нь хэлэлцүүлгийн үр дүн, аймаг сумдын хөгжлийн бодлогын баримт бичиг, Хамтын ажиллагааны гэрээ, ХДС-ийн дүрэм, санхүүжилтийн удирдамж болон бусад холбогдох баримт бичгүүдтэй уялдсан байна. | гурван жил тутамд |
| | Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт бүрээр ХДС-ийн баримтлах гурван жилийн үндсэн чиглэлийг батлуулах | • Гурван жилийн үндсэн чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлтийг Харилцааны хороогоор хэлэлцүүлж, Удирдах зөвлөлөөр батлуулна. | |
| 2 | ХДС-ийн гурван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө болон төсвийн төсөөллийг | • ХДС нь батлагдсан гурван жилийн үндсэн чиглэлийн дагуу жилийн төлөвлөгөө болон төсвийн төсөөлөл боловсруулж Харилцааны хороогоор хэлэлцүүлэн, Удирдах зөвлөлөөр батлуулна.<br>• Уг төлөвлөгөөнд дараах зүйлсийг оруулна<br>○ Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралтад заасан үндсэн чиглэлүүдээс тухайн жилд хэрэгжүүлэх чиглэлүүдийг сонгон тус бүрд | Жил бүрийн 6 сард |

| | | | |
|---|---|---|---|
| | боловсруулж батлуулах | төсвийн төлөвлөгөө гарган тооцоолол хийсэн байна<br>○ ХДС-ийн жилийн санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилсан төлөвлөгөө гаргана | |
| 3 | Үнэлгээний хороо байгуулах, ажлын даалгавар боловсруулах | • Аймгийн ЗДТГ нь жилийн төлөвлөгөөний дагуу холбогдох мэргэжлийн байгууллага болон иргэдийн оролцоог хангасан Үнэлгээний хороо байгуулна.<br>• Үнэлгээний хороо нь жилийн төлөвлөгөө болон батлагдсан төсөвт багтаан ажлын даалгавар боловсруулан ХДС-д ирүүлэх бөгөөд ХДС нь Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн гишүүдээс санал авч, ХДС нь санал, зөвлөмжийг нэгтгэн Үнэлгээний хороонд хүргүүлнэ. Саналыг ажлын 14 хоногийн дотор бичгээр ирүүлнэ<br>• Үнэлгээний хороо нь Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн саналуудад үндэслэн ажлын даалгаврыг эцэслэн боловсруулна. | 9 сар |
| 4 | Төслийн уралдаан зарлах, хүлээн авах | • Үнэлгээний хорооны эцэслэн боловсруулсан ажлын даалгаврын дагуу төслийн уралдаан зарлах бөгөөд Үнэлгээний хороо нь нийгмийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн саналыг ХДС-ийн төсөл хөтөлбөр хүлээн авах маягтын дагуу хүлээн авна.<br>• Ажлын даалгаврын дагуу төслийн саналаа ирүүлсэн эсэхэд Үнэлгээний хороо хяналт тавьж хүлээн авсан саналуудаа зөвлөмжийн хамт ХДС-д ирүүлнэ. | 3 сард |
| 5 | Төслийн саналыг эрэмбэлэх | • Харилцааны хороо нь Үнэлгээний хорооноос ирүүлсэн төслийн саналуудыг хэлэлцэж, эрэмбэлнэ.<br>• Харилцааны хороо нь төслийн саналуудад зөвлөмж өгөх эрхтэй. | 05 сард |
| 6 | Төслийн саналыг хэрэгжүүлэх шийдвэр гаргах | • ХДС-ийн Удирдах зөвлөл нь Харилцааны хорооноос ирүүлсэн хөтөлбөрийн саналуудыг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэж, хөтөлбөрийн хэрэгжүүлэгч (гүйцэтгэгч)-ийг сонгон шалгаруулна. | 06 сард |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Шийдвэрийг мэдээлэх | • ХДС нь Удирдах зөвлөлийн шийдвэрийн тухай Захиалагч болон санал ирүүлэгчид мэдээлнэ | 6 сард |
| 8 | Гэрээ байгуулах | • Аймгийн ЗДТГ сонгогдсон Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсны дараа тус гэрээний хуулбарыг албан тоотын хамт гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор ХДС-д хүргүүлнэ.<br>• Захиалагч сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан уг гэрээг албан тоотын хамт гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор ХДС-д хүргүүлнэ.<br>• Захиалагчаас албан тоотоор ирүүлсэн гэрээнд үндэслэн ХДС нь Захиалагч, Гүйцэтгэгчтэй санхүүжилтийн гэрээг байгуулна. Уг гэрээг байгуулахаас өмнө төслийн ажлыг эхлүүлэхгүй.<br>• Санхүүжилтийн гэрээг ажлын 14 хоногийн дотор байгуулна. Шаардлагатай тохиолдолд (нэмэлт материал бүрдүүлэх, холбогдох зөвшөөрөл авах г.м) энэ хугацааг сунгаж болно. | Тухай бүр |
| 9 | Төслийн хэрэгжилт, хяналт | • ХДС-ийн Хяналт, шинжилгээ- үнэлгээний журмын дагуу Захиалагч, ХДС, тэдгээрийн төлөөлөгчид төслийн аль ч үе шатанд хяналт тавина.<br>• Төслийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжилтийг дуусгавар болгох үйл ажиллагааг ХДС-ийн Хяналт, шинжилгээ- үнэлгээний журмын дагуу зохион байгуулна. | Төслийн төлөвлөгөөний дагуу |
| 10 | Төслийн тогтвортой байдал, мэдээлэл авах | • Төслийн саналд тусгасан төслийн тогтвортой байдлын төлөвлөгөөний дагуу Захиалагч, ашиглагч байгууллагууд нь тогтвортой байдлыг хангаж ажиллана. | Төслийн санхүүжилт бүрэн хийгдэж дууссанаас хойш |

Эрх бүхий өргөдөл гаргагчаас ХДС-д ирүүлсэн санал гэж ирүүлсэн Төсөл, хөтөлбөрүүдийг дараах дараалын дагуу үнэлж, шийдвэр гаргаж, хэрэгжүүлж, хянах бөгөөд дэлгэрэнгүй үйл явцыг “Говийн Оюу ХДС”-гийн холбогдох протоколд тусгасан болно. Зорилтот сумдад хуваарилсан хөрөнгийн эх үүсвэрт багтаан тухайн сумдын иргэд, төрийн бус байгууллага, хоршоо, нөхөрлөлийн санаачилсан төслийг хүлээн авах, сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг тухайн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг зохион

байгуулж шалгаруулсан төсөл, хөтөлбөрийн саналыг ХДС-гийн Гүйцэтгэх захиралд ирүүлнэ. ХДС-гийн Гүйцэтгэх захирал ХДС-гийн санхүүжилтийн журмын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж ажиллана.

Зорилтод сумдад хуваарилсан санхүүгийн дэмжлэгт багтаан тухайн суманд хэрэгжих төслийг сонгон шалгаруулахаас бусад үе шатны ажлууд, тухайлбал төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх гэрээ байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах зэрэг үйл ажиллагаанууд гагцхүү энэхүү журмын дагуу зохицуулагдана.

**Арав. Татвар**

Холбогдох хууль тогтоомж, гэрээний заалтыг баримтлан, Төслийн гүйцэтгэгч, захиалагч болон/эсхүл Төсөл, хөтөлбөрөөс гарах үр дүнд материаллаг ашиг сонирхол бүхий этгээд нь Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, боловсруулах, хэрэгжүүлэх, хүлээлгэн өгөхтэй холбоотойгоор ногдуулсан эсхүл тухайн Төсөл, хөтөлбөрийн аливаа холбогдох болон санамсаргүй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж болох аливаа болон бүх татвар, төлбөр, хураамжийг хариуцан төлөх үүрэгтэй.

**Арван нэг. Тайлбар**

Энэхүү Удирдамжаар Хамтын ажиллагааны гэрээ болон “Говийн Оюу ХДС”-гийн Дүрэмд аливаа нэмэлт, өөрчлөлтийг оруулаагүй болно. Энэхүү Удирдамж болон түүний аливаа хэсэг нь Хамтын ажиллагааны гэрээ болон “Говийн Оюу ХДС”-гийн Дүрэмд нийцээгүй эсвэл тэдгээрийн хүрээнээс гарсан тохиолдолд Удирдамжийг хэрэглэхгүй бөгөөд түүнийг суурь баримт бичгүүдтэй нийцүүлэх, тэдгээрийн хүрээнд байлгахад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

**Хавсралт 1.** **ХДС-д ирүүлсэн саналыг хүлээн авах, бүртгэх маягт**

**Хавсралт 2.** **Төсөл, Хөтөлбөрийн Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд**

**Хавсралт 3.** **Сэдэвчилсэн чиглэлүүдэд багцалснаар онцгойлон авч үзэх**

**Төсөл, Хөтөлбөрийн жишээ болон санхүүжилтийн**

**шалгууртай холбоотой эрх, үүргийн дэлгэрэнгүй товчоо**

**Хавсралт 4.** **Нийгмийн дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зураглал**

**Хавсралт 5.** **Нийгмийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зураглал**

*Please complete this proposal form clearly and concisely. A completed proposal should be between 3-5 pages.*
***Саналын анкетыг товч тодорхой, гаргацтай бөглөнө үү. (Ирүүлж буй санал 3-5 хуудас байна.)***

| **GENERAL IMFORMATION-ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ** | | | |
|---|---|---|---|
| Name of applicant:<br>***Төсөл санаачлагчийн нэр*** | | Project targeted area within Umnugobi:<br>***Өмнөговь дахь төслийн зорилтот газар*** | |
| Name of proposal:<br>***Ирүүлсэн саналын нэр*** | | Contact address:<br>***Холбоо барих-хаяг*** | |
| Date of submission:<br>***Санал ирсэн огноо*** | | Contact phone, email**: *Холбоо барих утас, цахим шуудан*** | |
| **PLAN DATE-ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОГНОО** | | **FUNDING RESOURCES –*САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР*** | |
| Project start date**: *Төслийн эхлэх хугацаа*** | | Amount of Total budget<br>***Нийт төсвийн хэмжээ*** | __MNT/₮ |
| | | Requested amount from the Fund<br>***Сангаас хүсэж буй хэмжээ*** | __MNT/₮ |
| Project completion date**:**<br>***Төслийн дуусах хугацаа*** | | Other financial source (if any)<br>***Бусад санхүүгийн эх үүсвэр(хэрэв байгаа бол)*** | __MNT/₮ |

**PLEASE TICK THE RELEVANT SECTIONS FROM THE FOLLOWING AREAS OF DSF PRIORITY-**

☐ Water management - ***Усны менежмент***

☐ Environmental management and protection (rehabilitation, biodiversity and ecological balance) – ***Байгаль орчны менежмент, хамгаалал (Нөхөн сэргээлт, биологийн төрөл зүйл болон экологийн тэнцвэр)***

☐ National history, culture and Tourism- ***Үндэсний түүх соёл, аялал жуулчлал***

☐ Basic social services (health, education, vocational training and employment)- ***Нийгмийн суурь үйлчилгээнүүд(эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлт)***

☐ Traditional animal husbandry and pasture land management- ***Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн газрын менежмент***

☐ Local business development and procurement of goods and services – ***Орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, тэдгээрээс бараа, үйлчилгээ худалдан авалт***

☐ Infrastructure and capital projects – ***Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөл***

| PLEASE TICK THE ENTITY TYPE- БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨ ЗӨВЛӨН ТЭМДЭГЛЭНЭ ҮҮ | | |
|---|---|---|
| ☐ NGOs- ***Төрийн бус байгууллагууд*** | ☐ Cooperatives- ***Нөхөрлөл хоршооллын***<br>☐ Government agencies/organizations- ***Төрийн болон төсөвт байгууллага***<br>☐ Herder business***- мал аж ахуйн бизнес*** | ☐ Local government organization- ***Нутгийн захиргааны байгууллага***<br>☐ Local companies- ***Орон нутгийн компаниуд***<br>☐ SMEs- ***Жижиг дунд аж ахуй нэгж***<br>☐ Individual- ***Хувь хүн*** |

| PROJECT DESCRIPTION- ТӨСЛИЙН ТАЙЛБАР | |
|---|---|
| Project, program rationality and objectives- ***Төслийн үндэслэл ба зорилго*** | |
| Project outcomes and results (it should be measurable by KPIs)<br>***Төсөл, хөтөлбөрийн хүлээгдэж буй үр өгөөж, үр дүн(хэмжиж болохуйц байх)*** | |
| Implementation mechanism for proposed projects and programs<br>***Санал болгосон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны хэрэгжилтийн механизм, бүтэц*** | |

| | |
|---|---|
| Project, program beneficiaries, and its involvement in the proposal development, reflection of their needs including support for capacity development –<br><br>***Төсөл, хөтөлбөрийн үр шимийг хүртэгчид, төсөл, хөтөлбөрийн саналыг боловсруулах, хэрэгжүүлэх шатанд тэдний оролцоо, тэдний чадавхыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх, хэрэгцээнд тулгуурласан байдал*** | |
| Project, program direct positive impacts and sustainable benefits on community livelihood-<br><br>***Нутгийн иргэдийн амьдрал ахуйд шууд эергээр нөлөө үзүүлэх ба тогтвортой үр өгөөж өгөх тухай*** | |
| Procurement plan if project will procure any goods and services related to the project and program<br><br>***Төсөл хөтөлбөртэй холбоотой аливаа бараа, үйлчилгээ ил тод худалдан авах төлөвлөгөө*** | |
| Please provide project implementation plan (with performance milestones and execution timeframes identified) for proposed projects and programs.<br><br>***Санал болгож буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний гүйцэтгэлийн хугацаа болон шатлалыг тусгах*** | |

| | |
|---|---|
| Monitoring plan to meet statutory requirements, in particular those relating to infrastructure projects-<br><br>***Санаачилсан төсөл тань хуулийн хүрээнд байгаа эсэхийг хянах төлөвлөгөөтэй байх  ялангуяа дэд бүтэцтэй холбоотой төслийн саналтай бол*** | |
| Please provide health, safety and environmental risk assessment of the project.<br><br>***Төслийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны эрсдэлийн үнэлгээг өгнө үү.*** | |
| Project, program sustainability plan after a completion of project grant<br><br>***Төсөл, хөтөлбөр хэрэгжих дууссаны дараах тогтвортой байдлын төлөвлөгөө*** | |
| Applicant's professional experience in the project area<br><br>***Санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байсан туршлага*** | |
| Replicating or overlapping with existing projects, programs<br><br>***Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдтэй агуулгын хувьд адилхан ба давхцаж буй эсэх*** | |
| Collaboration with other organizations for maximum impact<br><br>***Төслийн  үр нөлөөг хамгийн их болгох зорилгоор бусад байгууллагуудтай хамтарч ажиллах байдал*** | |

| PLEASE SUBMIT THE FOLLOWING DOCUMENTS ALONG WITH YOUR PROJECT PROPOSAL-<br><br>ДООР ДУРДСАН МАТЕРИАЛУУДЫГ ТӨСЛИЙН САНАЛТАЙ ХАВСАРГАНА УУ | |
|---|---|
| ☐ Project or program proposal- ***Төсөл хөтөлбөрийн санал***<br><br>☐ Detailed cost breakdown - ***Зардлын задаргааны дэлгэрэнгүй***<br><br>☐ Approved design or Engineering drawings- ***Батлагдсан загвар, Зураг төсөл***<br><br>☐ Execution plan (detail) - - ***Гүйцэтгэлийн төлөвлөгөө***<br><br>☐ Feasibility Study, Environmental impact assessment report and geotechnical study report- ***Техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан, геотехникийн судалгааны тайлан*** | ☐ Land allocation permits- ***Газар эзэмших зөвшөөрөл***<br><br>☐ HSEC risks assessment and controls are identified- ***ЭМААБО-ийн эрсдэлийн үнэлгээ болон хяналтын тодорхойлолт***<br><br>☐ Utility connection permits- ***Байгууламжийн холболт хийх зөвшөөрөл***<br><br>☐ Financial report of 3 years and income/loss statement-audited- ***Аудитаар шалгагдсан ашиг/алдагдлын 3 жилийн санхүүгийн тайлан***<br><br>☐ Letter of recommendation from local governor's office- ***Нутгийн захиргааны байгууллагын дэмжсэн тоот***<br><br>☐ Copy of company or NGO certificate- ***Компанийн болон ТББ гэрчилгээний хуулбар***<br><br>☐ Copy of citizen identity card– ***Иргэний үнэмлэхийн хуулбар*** |

**RECEIVED AND REGISTERED BY: /ХҮЛЭЭН АВЧ БҮРТГЭСЭН:**

________________________________ /name- нэр/ ______________________ /signature- гарын үсэг/ __________ date- өдөр

**SUBMITTED BY:/ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:**

Applicant: Өргөдөл гаргагч ___________________ /name-нэр/ ___________ /signature- гарын үсэг / __________ date- өдөр

| **ХАВСРАЛТ 2: Төсөл, Хөтөлбөрийн Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд /ГҮҮ/** | | |
|---|---|---|
| **KPI/ГҮҮ** | **Хэмжих арга** | **Давтамж** |
| **KPI 1**<br>Төсөл, хөтөлбөрүүдийг тавигдсан зорилго, хамрах хүрээ, ажлын хуваарь, батлагдсан төсвийн хүрээнд гүйцэтгэсэн байдал | Гүйцэтгэлийн явцын үнэлгээний тайлан<br><br>Санхүүгийн тайлан | Хагас жил тутам |
| **KPI 2**<br>ХДС-гийн тэргүүлэх чиглэл болон ХАГ-ийн Сэдэвчилсэн Хавсралттай уялдсан байдал | Гүйцэтгэлийн явцын үнэлгээний тайлан | Хагас жил тутам |
| **KPI 3**<br>Үр өгөөж хүртсэн орон нутгийн иргэдийн тоо | Гүйцэтгэлийн явцын үнэлгээний тайлан<br>Орон нутгийн иргэдийн санал сэтгэгдэл, судалгаа | Хагас жил тутам |
| **KPI 4**<br>Худалдан авалтын ил тод байдал | Хэрэгжилтийн өмнөх Худалдан авалтын тайлан<br>Орон нутгийн иргэдийн санал сэтгэгдэл, судалгаа | Хагас жил тутам |
| **KPI 5**<br>Олон нийтийн эерэг хандлага | Орон нутгийн иргэдийн санал сэтгэгдэл, судалгаа | Хагас жил тутам |
| **KPI 6**<br>Төсөл хөтөлбөрийн тогтвортой байдал | Гарах төлөвлөгөө<br>Ашиглалт, үйл ажиллагааны төлөвлөгөө | Жил тутам |

| **ХАВСРАЛТ 3. Сэдэвчилсэн чиглэлүүдийн дагуу багцалсан онцгойлон авч үзэх Төсөл. Хөтөлбөрүүдийн жишээ болон санхүүжилтийн шалгууртай холбоотой х эрх, үүргийн дэлгэрэнгүй товчоо** | | |
|---|---|---|
| **Сэдэвчилсэн чиглэлүүд** | **Тайлбар** | **Онцгойлон авч үзэх Төсөл, Хөтөлбөрийн жишээ (жишээгээр хязгаарлагдахгүй)** |
| **Нийгмийн суурь үйлчилгээ (Эрүүл мэнд, соёл, боловсрол, мэргэжлийн сургалт, хөдөлмөрийн чадвар – Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 8)** | **Боловсрол** | |
| | Боловсролын ач холбогдлыг сурталчлах, түүнчлэн бага насны болон сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | Боловсролын чанар сайжруулах санаачилга:<br>• Боловсролын чанарыг үнэлэх, сайжруулах хөтөлбөрүүд,<br>• Сурган хүмүүжүүлэгч, багш нарын мэргэжил дээшлүүлэх, манлайллын сургалт<br>• Эцэг эхийн боловсрол, оролцоог хангах хөтөлбөр;<br>• Хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүд,<br>• Бага насны хүүхдийн гэр бүлийн боловсрол |
| | Иргэд ба залуу манлайллыг хөгжүүлэн, давуу чанаруудыг олж харах | Залуучууд хөгжлийн хөтөлбөрүүд, насанд хүрэгчид болон ахмадуудад чиглэсэн албан бус сургалтын хөтөлбөрүүд, насан туршийн сургалтын хөтөлбөрүүд |
| | Зохистой эрдэм шинжилгээний, ажил мэргэжлийн боловсрол болон сургалтад хамрагдах боломжийг ихэсгэх | • Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш нарыг чадавхжуулах сургалт<br>• Лаборатори, анги танхимын шинэчлэл гэх мэт техникийн тусламж |
| | **Эрүүл мэнд** | |
| | Эрүүл мэнд, аюулгүй байдал (замын хөдөлгөөний аюулгүй байдал), нийгмийн сайн сайханд чиглэсэн хөтөлбөрүүдийг дэмжих | • Иргэдийн эрүүл мэндийн үнэлгээ,<br>• Иргэдийн дадал, хандлагыг өөрчлөх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх хөтөлбөрүүд,<br>• Иргэдийн аюулгүй байдалд чиглэсэн хөтөлбөрүүд,<br>• Иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд чиглэсэн хөтөлбөрүүд, |
| | Боловсролын болон эрүүл мэндийн үйл ажиллагаагаар дамжуулан иргэдийн ур чадварыг хөгжүүлж, тэдний сайн сайхан, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрүүдийг дэмжих | |

| | | |
|---|---|---|
| | | • Иргэдэд хог хаягдалгүй, эрүүл орчинд аж төрөх дадал, хэвшил төлөвшүүлэх, усны чанарын тухай мэдлэг олох сургалт |
| | Эрүүл мэндийн байгууллагын ажилчдын чадварыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог сайжруулах | • Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт,<br>• Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, явуулын эмчийн үйлчилгээ<br>• Иргэдийн дунд шаардлагатай анхны тусламжийн сургалтыг зохион байгуулж аюул осолгүй байх үндэс тавих<br>• Эрүүл мэндийн удирдлагын системийг сайжруулах хөтөлбөрүүд |
| **Байгаль орчин, усны менежмент- Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 4, 5** | Далайцтай өөрчлөлт оруулах хөтөлбөрүүдийг дэмжих – “Оюу Толгой” ХХК-ийн явуулдаг үйл ажиллагаанаас гадна<br>Өмнөговь аймагт тулгамдаж буй байгаль орчны асуудлуудын тухай танин мэдүүлэх хөтөлбөрүүдийг дэмжих<br>Бүсийн байгаль орчны чанарыг сайжруулах иргэдэд чиглэсэн хөтөлбөрүүдийг дэмжих | • Усны нөөцийн хамгаалалт<br>• Ногоон байгууламж, үржүүлгийн санаачилга<br>• Цөлжилттэй тэмцэх иргэдийн оролцоо нэмэгдүүлэх ажлыг хөгжүүлэх<br>• Цөлжилттэй тэмцэх<br>• Байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлттэй холбоотой иргэдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх<br>• Экологийн системийн үйлчилгээг таниулах сургалт<br>• Байгаль орчин хамгаалагчдын ур чадварыг дээшлүүлэх<br>• Ус болон тогтвортой байдлыг иргэдэд таниулах |
| **Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент – Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 6** | Малчдын амьдрал ахуйг дээшлүүлж, малчин өрхийн орлогын эх үүсвэрийг ихэсгэхэд дэмжлэг үзүүлэх<br>Уламжлалт тогтвортой мал аж ахуй, нүүдлийн бэлчээрийн хэрэглээ, хадгалалтыг дэмжих<br>Малчдын хоршооллын тогтвортой байдлыг дэмжих | • Малын эрүүл мэнд, эмнэл зүйн үйлчилгээний үнэлгээ<br>• Мал үржүүлгийн болон малын эмч нарын ур чадварыг дээшлүүлэх<br>• Малын эмч, мал үржүүлгийн ажлын лабораторийн үнэлгээ, судалгаа хийх, тэдгээрийн чанар, хүртээмжийг сайжруулах хөтөлбөрүүд<br>• Малын эмч, зоотехникч мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтууд |

| | | |
|---|---|---|
| | | • Малын эрүүл мэнд, үржил селекц, чанар, бэлчээр, усны нөөцийн хяналт үнэлгээний талаар малчдад мэдлэг мэдээлэл өгөх сургалт<br>• Бэлчээрийн менежмент сайжруулах хөтөлбөрүүд<br>• Худаг ус гаргах, сэргээн засварлах, хөв байгуулах санаачилга<br>• Малын тэжээлийн ургамал тариалах, үйлдвэрлэх санаачилга<br>• Бэлчээрийн болон малын эрүүл ахуйн хөтөлбөрүүд<br>• Малчдад бэлчээр ашиглалтын тухай мэдлэгийн төлөвшүүлэх сургалт<br>• Залуу малчин хөгжлийн хөтөлбөрүүд,<br>• Малчдын нөхөрлөл хоршоолол багийн хөгжлийн хөтөлбөрүүд |
| **Үндэсний түүх соёл, аялал жуулчлал – Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 7** | Өмнөговь аймгийн биет болон биет бус соёлын, байгалийн өв, түүхийг хамгаалах хөтөлбөрүүдийг дэмжих<br>Түншлэгч сумдын “амьд ахуйн соёл”-ын хөгжил цэцэглэлтэд чиглэсэн хөтөлбөрүүдийг дэмжих<br>Иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх иргэдэд чиглэсэн аялал жуулчлалын хөтөлбөрийг дэмжих | • Биет болон биет бус соёлыг хамгаалан сэргээн засварлах хөтөлбөрүүд<br>• Байгалийн ба түүхийн өв болсон газрын хамгаалалт<br>• Эко соёлын аялал жуулчлал иргэдэд чиглэсэн жуулчлалыг сурталчлах<br>• Орон нутгийн музейг шинэчлэх, сайжруулах<br>• Соёлын өвийн талаар иргэдэд мэдлэг мэдээлэл өгөх |
| **Нийгмийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөл – Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 10** | Иргэдэд бодит өгөөж авчрах нийгмийн дэд бүтцийн төслүүдийг дэмжих. Эрүүл мэнд болон боловсролыг нэн тэргүүнд авч үзнэ. | Дараах шинж чанартай төслүүдийн зураг, төсөв, барилга угсралт, засварын ажил хийх:<br>• Цэцэрлэг болон сургуулийн зориулалттай барилга байгууламж, өрхийн болон сумын эмнэлэг тэдгээртэй ижил төстэй барилга, байгууламж<br>• Иргэдийн эрүүл ахуй, аюулгүй байдалд чиглэсэн бага оврын байгууламжууд, тухайлбал, хог хаягдал зайлуулах байгууламж, ус цэвэршүүлэх байгууламж, нийтийн бие засах газар, явган зам, замын тэмдэг тэмдэглэгээ, дугуйн зам, үер уснаас хамгаалах хоолой, шуудуу татах, халаалтын зуух, малын эрүүл мэнд, үржил |

| | | |
|---|---|---|
| | | селекц, лабораторийн байгууламж, иргэдийн хөгжлийн төвүүд<br>• Аливаа инженерийн дэд бүтцийн болон том оврын байгууламжуудын зураг төсөл, барилга угсралтын ажил, цахилгаан дамжуулах шугам, дэд станц, бусад холбогдох барилга байгууламж, ус хангамжийн шугам ба байгууламж, ариутгах татуурга ба байгууламж, холбооны шугам сүлжээний барилга угсралт гэх мэт<br>*Дэмжихгүй:*<br>• Хатуу хучилттай зам, гүүр, зугаа цэнгэлийн газар<br>• Төрийн засаг захиргааны барилга, түүний засвар<br>• “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас урьд нь санхүүжүүлсэн барилгын засвар |
| **Орон нутгийн бизнес хөгжил, бараа үйлчилгээ худалдан авалт – Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 9** | Өмнөговь аймгийн эдийн засгийн олон талт байдал болон өрсөлдөх давуу талыг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг дэмжих<br>Жижиг бизнесүүдэд туслах, тогтвортой ажил үйлчилгээ явуулах бизнесийг татах хөтөлбөрүүдийг дэмжих.<br>Эдийн засагт хувь нэмэр оруулах бүсийн хамтын ажиллагаа, ур чадварыг нэмэгдүүлж бэхжүүлэх хөтөлбөрүүдийг дэмжих | Жижиг болон дунд бизнес эрхлэгчид, бизнесийн инкубаторуудын чадварыг дээшлүүлэх, сургалт, зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх |

| Санхүүжилтийн шалгууртай холбоотой эрх, үүргийн дэлгэрэнгүй товчоо | | |
|---|---|---|
| **Хариуцагч** | **Үүрэг** | **Санхүүжилтийн шалгуур** |
| **ХДС-гийн Гүйцэтгэх захирал** | Хүлээн авах, бүртгэх, саналын материалын бүрдэлд хяналт тавих, Санхүүжилтийн удирдамжийн шалгуурын дагуу анхан шатны үнэлэлт хийх | Саналын бүрэн бүтэн тогтвортой байдал: |
| | | *Бүрэн бөглөсөн саналын маягт* |
| | | *Аудитаар шалгагдсан 3 жилийн санхүүгийн тайлан - ашиг алдагдлын тайлан, эсвэл төслийг хэрэгжүүлж чадах чадвартайг баталсан бусад бичиг баримт* |
| | | *Иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл нотариатаар баталгаажуулсан компанийн эсвэл ТББ –ын гэрчилгээ* |
| | | *Тодорхой хэрэгжүүлэх бүтэц болон удирдлага* |
| | | *Дэлгэрэнгүй хэрэгжүүлэлтийн хуваарь* |
| | | *Тодорхой зардлын задаргаа* |
| | | *Төсөл, хөтөлбөрийн багийн дэлгэрэнгүй намтар* |
| | | Бусад шалгуурууд: |
| | | *Өмнөговь аймагт хэрэгжих* |
| | | *Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн чиглэлтэй уялдсан байх* |
| | | *Саналд нэмэлт инженерийн, санхүүгийн эсвэл хуулийн хяналт тавих шаардлагатай эсэхийг авч үзэх* |
| | | *ХАБ-тай холбоотой эрсдэлүүдийг тодорхойлж төлөвлөгөө гаргасан эсэхийг авч үзэх* |
| | | *Ил тод худалдан авалтын бодлогын асуудал (Өмнөговь болон түүнээс дээш түвшинд гүйцэтгэлтэй холбоотойгоор)* |
| | | *Нийгэмд хүрэх үр өгөөж хэмжих болохуйц байх* |
| **Харилцааны хороо** | Саналыг Санхүүжилтийн удирдамжид нийцүүлэх хянаж үзэх<br><br>Мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч төслийн тогтвортой урт хугацаанд үр өгөөжөө өгөх тал дээр дүн шинжилгээ хийх | Дараах бичиг баримтад нийцэж байгаа эсэхийг авч үзэх:<br>1. ХДС-гийн санхүүжилтийн шалгуур болон шаардлагууд<br>2. Аймаг болон Түншлэгч сумдын хөгжлийн чиглэлийн уялдаа<br>3. “Оюу Толгой” ХХК, Аймаг, Түншлэгч сумдын зэрэг харилцаа холбоо, түншлэлд бодитой хувь нэмэр оруулж байгаа |
| | | Түншлэгч сумд: |
| | | *Түншлэгч сумд: Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумд* |
| | | *Уул уурхайгүй сумд: Сэрвэй, Булган, Ноён, Баяндалай, Цогт-Овоо, Номгон* |
| | | *Бусад 5 сум – хамтарсан санхүүжилт хийнэ* |

| | | |
|---|---|---|
| | Санхүүжилтийн удирдамжийн шалгууруудад нийцэж байгаа саналуудыг ХДС-гийн Удирдах зөвлөлийн гишүүдэд хүргүүлэхдээ төрөл, цаг хугацаа, бодит үр өгөөж, нийгмийн хэрэгцээ шаардлага мөн бусад хүчин зүйлүүдийг харгалзан үзэж эрэмбэлсэн эрэмбэ, зөвлөмжийн хамт танилцуулна.<br><br>Нээлттэй хэлэлцүүлэг болно. Оноо өгч, дугаарлах журмаар эрэмбэлж болно.<br><br>Шийдвэрийг санал нэгтэйгээр гаргахыг зорино.<br><br>ХДС болон Харилцааны хороо нь улс төрийн үүднээс хандахгүй ба нийгмийн сайн сайхны төлөө төвийг сахин ажиллана. | ХДС-гийн зорилтот бүлэг болох хүүхэд залуучууд, малчид, эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон эмэгтэйчүүдийг дэмжих |
| | | Төсөл хөтөлбөрийн тогтвортой байдал: |
| | | *Үйл ажиллагааны төлөвлөгөө (төсөв болон ажиллах хүч) – Явцын төсөв хаанаас гарах вэ?* |
| | | *Эзэмшил болон удирдлага – улс төрийн нөлөөлөлгүй байж төслийг хэрэгжүүлэх хүн, байгууллага, хэлтэс байх ёстой* |
| | | *Үйл ажиллагаа болон засвар хийх бусад санхүүжилтийн эх үүсвэр – ХДС-аас санхүүжүүлэхгүй* |
| | | *Одоо байгаа төсөл хөтөлбөртэй давхцаагүй байдал* |
| | | Төслийн хүрээнд хамгийн их үр дүнд хүрэх зорилгоор бусад байгууллагатай хамтран ажилладаг байдал болон төслийн хүрээн дэх туршлага |
| | | Төсөл, хөтөлбөрийн саналыг санаачлагч болон захиалагчийн ур чадвар болон найдвартай байдал |
| | | Гүйцэтгэх захирлын хянасан байдлыг авч үзэж аливаа залруулга, өөрчлөлт оруулах шаардлагатай бол тусалж ХДС-гийн Удирдах зөвлөлөөр авч хэлэлцэхэд хангалттай түвшинд хүргэх |

| | | |
|---|---|---|
| **ХДС-гийн Удирдах зөвлөл** | Харилцааны хорооны зөвлөмж болон үнэлэлтийг хянаж эцсийн дэмжих, эс дэмжих шийдвэр гаргах | Гүйцэтгэх захирал болох Харилцааны хорооны хянаж үнэлсэн саналуудыг авч хэлэлцэх<br><br>Саналтай холбоотой түүний үндэслэлтэй, аюулгүй тогтвортой байдлыг үзэх зорилгоор хийлгэсэн хөндлөнгийн мэргэжилтний хийсэн инженер, санхүү, хуулийн үнэлгээ өгсөн тайлантай танилцаж Гүйцэтгэх захирал болон Харилцааны хорооны зөвлөмж, тэдний тайланг авч үзэх<br><br>Саналын эрэмбэ болон эрэмбэтэй холбоотой Харилцааны хорооны зөвлөмжийг харгалзан үзэх<br><br>Санхүүжилтийн удирдамжийн шалгууруудад нийцэж байгаа эсэхийг шалгаж хянах<br><br>Санхүүжилтийн удирдамж, ХДС-гийн дүрэм болон Хамтын ажиллагааны гэрээнд нийцүүлэх  бусад бүх хүчин зүйлийг харгалзан үзнэ |

## Нийгмийн дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэх үйл явцын зураглал



## Нийгмийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцын зураглал

